

**Монгол албан бичгийн уламжлал хийгээд
дөрвөлжин бичгийн дурсгалууд**

Жанчив Ё.
/МУИС/

Хубилай (1215-1294) хааны зарлигаар Төвдийн Пагва лам Лодойжалцан (1235-1280) 1269 онд дөрвөлжин бичгийг зохиожээ.

Энэхүү бичиг нь хэлбэр дүрсийн хувьд төвд үсэгт суурилсан боловч дээрээс доош бичих тул монгол бичгийн ёс журмыг багагүй анхаарсан байдаг. Пагва лам хаантны даалгавраар шинэ бичиг зохион дуусмагц, тэрхүү үсгийг Монголын эзэнт гүрэн даяар нийдэм хэрэглэх тухай Хубилай хааны зарлиг гарчээ. Уг зарлигийг сийрүүлбэл;

“Би санаваас үсгээр үгийг бичмүй. Үгээр хэргийг тэмдэглэмүй. Энэ нь эрт ба эдүгээгийн нэвтэрхий хууль. Бидний улс гэр умард газар тулгар байгуулсан тул суртал нь хэмжээтэй, эртийг эрхлэх тулд тогтоол үүсгэж завдсангүй. Аливаа хэрэглэх бичиг үсэг нь хятад хичээнгүйлэх ба жич уйгар үсгийг хэрэглэж манай улсын үгийг нэвтрүүлмүй. Ляо улс, Алтан улс ба жич холхи олон улсын дүрмийг хянаваас тус тустаа үсэг буй амуй. Эдүгээ бас бичгийн засаг улмаар хөгжих бөгөөд бичиг үсгийг тогтоох нь дутуу бүрдээгүй тул ийнхүү тусгайлан улсын багш Пагвад тушааж Монголын шинэ үсгийг үүсгэн бичүүлвэй. Аливаа бичиг үсгийг орчуулан бичихүйд үгийг дагаж хэргийг нэвтрүүлэхийг эрмэлзэх байх нь. Үүнээс хойш аливаа хас тамга дарах бичиг тархаан буулгахүйд нь хамтаар Монголын шинэ үсгийг хэрэглэж, басхүү тус туст түүний улсын үсгийг хавсруулагтун”¹ гэжээ.

Энэ зарлигийн үг үсгийг анхааралтай уншхул, дөрвөлжин үсгийг эзэнт гүрний албан ёсны бичиг болгох гэсэн Хубилай хааны санаа тодорхой мэдэгдэж буй.

Дөрвөлжин үсгийн дурсгал төдий л арвин бус ч гэсэн нангиад, монгол, төвд, самгард, түрэг зэрэг 5 хэлээр бичсэн чамлахааргүй зүйл уламжлан иржээ.

Монгол хэлээрх дурсгал тоо хэмжээгээрээ нангиад дурсгалын дараа орж байгаа билээ. Сүүлийн үед шинэ шинэ дурсгал ч нээгдсээр байна. Эдүгээ шинжлэх ухаанд мэдэгдээд буй дөрвөлжин үсгийн монгол дурсгалыг дотор нь зүйлчлэн хувааж доор жагсаавал²;

¹ Д.Чойжалсүрэн. Монголын дөрвөлжин үсэг. УБ., 1974. (12 тал). 3

² Дөрвөлжин үсгийн монгол дурсгалын судлалаар гарсан гол бүтээлүүд гэвэл;

А. Хөшөө чулуу болон цаасан дээр үйлдсэн хаад ноёд, ихэс дээдсийн зарлиг

1. Мангалын үг (1276)
2. Хубилай хааны зарлиг (1277~1289) (1)
3. Хубилай хааны зарлиг (1277~1289) (2)
4. Хубилай хааны зарлиг (1277~1289) (3)
5. Хубилай хааны зарлиг (1280~1292)
6. Анандын үг (1282)
7. Анандын үг (1283)
8. Өлзийт хааны зарлиг (1294)
9. Өлзийт хааны зарлиг (1298)
10. Өлзийт хааны зарлиг (1301)
11. Се'үсегийн үг (1303)
12. Хан хөвгүүн Хайшаны үг (1305)
13. Өлзийт хааны зарлиг (1306)
14. Хайсан хүлэг хааны зарлиг (1309)
15. Буянт хааны зарлиг (1312) (1)
16. Буянт хааны зарлиг (1312) (2)
17. Буянт хааны зарлиг (1313)
18. Буянт хааны зарлиг (1314) (1)
19. Буянт хааны зарлиг (1314) (2)
20. Буянт хааны зарлиг (1314) (3)
21. Буянт хааны зарлиг (1314) (4)
22. Наньхуа сүм дэх Буянт хааны зарлиг (1)
23. Наньхуа сүм дэх Буянт хааны зарлиг (2)
24. Буянт хааны зарлиг (1318)
25. Дармабалын хатны ижи (1320)
26. Дармабалын бэлбэсэн хатны ижи (1321)
27. Хааны багш Гунгаалодойжалцанбалсанбуугийн фажи (1321)

M. Lewicki. Les inscriptions mongoles inédites en écriture carrée (=CO. No. 12). Wilno. 1937. 72 pp.

H. N. Poppe. Квадратная письменность. М.-Л., 1941. 168 сс.

N. Poppe. The Mongolian Monuments in ᠬᠠᠭᠤᠰᠤᠩᠭ᠋ᠠᠨ Script. (=Göttinger Asiatische Forschungen 8). Trans. and ed. by J. R. Krueger. Wiesbaden. 1957. XII+147 pp+13 pl+1 map.

L. Ligeti. ᠬᠠᠭᠤᠰᠤᠩᠭ᠋ᠠᠨ írásos emlékek. Kancelláriai iratok kínai átírásában: Mongol Nyelvelmélektár II. Budapest. 1964. (155 pp), 3-116.

L. Ligeti. Monuments en écriture ᠬᠠᠭᠤᠰᠤᠩᠭ᠋ᠠᠨ. Pièces de chancellerie en transcription chinoise. MLMC. III. Budapest. 1972. (170 pp), 9-128.

尼. 鮑培. 巴思八字蒙古语碑铭, 译补, 内蒙古文化出版社, 1986. 455 pp.

照那斯图. 巴思八字和蒙古语文献. I. 研究文集. 東京, 1990. 169 pp. II. 文献汇集. 東京, 1991. 228 pp.

Ё. Жанчив. Дөрвөлжин үсгийн монгол дурсгалын хэлний судалгаа. (Хэл бичгийн ухааны доктор (Ph. D)-ын зэрэг горилсон зохиол). УБ., 2000. 188+162 тал.

Ё. Жанчив. Дөрвөлжин үсгийн монгол дурсгал (Эх, үсгийн галиг, хөрвүүлэг, үгийн хэлхээ, нэмзүй), MONUMENTA MONGOLICA: t. III, Centre for Mongol Studies. National University of Mongolia. УБ., 2002. 195 тал.

Д. Төмөргогоо. Монгол дөрвөлжин үсгийн дурсгалын судалгаа (Удирдхал, эх бичиг, үсгийн хэлхээ, ном зүй), Monuments in Mongolian Language, The International Association for Mongol Studies. vol. II. УБ., 2002. 182 тал.

呼格吉勒图. 萨如拉. 巴思八字蒙古语文献汇编, 内蒙古教育出版社. 2004. 537 pp.

28. Гэгээн хааны зарлиг (1323)
29. Есөнтөмөр хаан зарлиг (1324) (1)
30. Есөнтөмөр хаан зарлиг (1324) (2)
31. Есөнтөмөр хаан зарлиг (1328) (?)
32. Тогоонтөмөр хааны зарлиг (1335)
33. Тогоонтөмөр хааны зарлиг (1336)
34. Тогоонтөмөр хааны зарлиг (1342)
35. Тогоонтөмөр хааны зарлиг (1343)³
36. Тогоонтөмөр хааны зарлиг (1345)
37. Тогоонтөмөр хааны зарлиг (1351)
38. Тогоонтөмөр хааны зарлиг (1362)
39. Тогоонтөмөр хааны зарлиг (1368)
40. Хүйтэний голын бичээс (Монгол улс, Дархан-Уул аймаг)

В. Цавчаал боолтын бичээс (1345)

41. Зүүн хаалганы бичээс
42. Баруун хаалганы бичээс

С. Пайз буюу гэрэгэний бичээс

43. Минусийн пайз
44. Нюкийн пайз
45. Боготолын пайз
46. Б. И. Панкратовын пайз
47. Хятадаас хожуувтар олдсон пайз
48. Дашлхүмбээс олдсон пайз
49. Өвөр Монголын Хянган аймгаас олдсон солон алтан пайз

Д. Тамга захирлагийн бичээс

50. Өлзийт султаны тамга (1305)
51. Галдан бошогтын тамга (1691)
52. Даваач ноён тамга (1750)
53. Номч мэргэн хамбын тамга
54. Мэргэн хамбын тамга
55. Да лам цорж мэргэн хамбын тамга
56. Наробанчен хутагтын тамга

Е. Ном судар, бичиг баримт

57. Субашидийн тасархай хуудас (3 ширхэг)
58. Субашидийн шинээр олдсон тасархай

³ Дөрвөлжин үсгээр үйлдэж, доор нь нангиад хадаж орчуулсан Тогоонтөмөр хааны хонин жил (1343)-ийн зарлигийн хуулбар (цаасан хэв)-ыг бид 1999 онд олж аваад урьд өмнө нь шинжилгээ судалгааны эргэлтэнд ороогүй зүйл байсан тул судлан нийтэлж олны хүртээл болгосон билээ. Энэхүү гэрэлт хөшөө БНХАУ-ын нутагт байсан нь тодорхой боловч эдүгээ хаана байгаа, хуулбар нь хэдийд, ямар замаар манай улсад орж ирсэн зэрэг нь тодорхойгүй байна. Ё. Жанчив, Монгол дөрвөлжин үсгээр бүхий Тогоонтөмөр хааны хонин жилийн зарлиг, "Монгол судлалын ЭШБ", МУИС, МСС, УБ., 2000, (284 тал), 77-86

59. Нэр нь үл мэдэгдэх нангиад-монгол номын тасархай

60. Стамбулийн бичиг

F. Бусад дурсгал

61. Тайхар чулууны бичээс (Архангай аймгийн Ихтамир сум)⁴

62. “Хавцалын адаг”-ийн бичээс (Сүхбаатар аймгийн Мөнххаан сум)⁵

63. Тунхаг бичиг (1306) (1)

64. Тунхаг бичиг (1307) (2)

65. Тунхаг бичиг (3)

66. Дарсны ваар дээрх бичээс

67. Нангиад бичээстэй хөшөөний магнайн үг (1335)

68. Чулуун дээр үйлдсэн бичээс

69. Нэгэн овгийн нэр

70. Алтан ордоны үйсэн дээрх бичиг дэх ганц мөр бичээсийн хэсэг гэх мэт нийт 70 дурсгал олдоод байна.

Эдгээр дурсгалт бичгүүдээс монгол албан бичгийн төрөл зүйлд хамаарах нь;

A. Хаад ноёд, ихэс дээдсийн зарлиг (40 ширхэг),

B. Гэрэгэний бичээс (7 ширхэг),

C. Тамга захирлагийн бичээс (Монгол хэлээр 7, нангиад хэлээр 100 гаруй) зэрэг болно. Эдгээрийг тусгайлан авч үзье.

A. Хаад ноёд, ихэс дээдсийн зарлиг

Дөрвөлжин бичгийн албан бичгийн төлөөлөх чанар бүхий гол дурсгал бол ихэс дээдсийн зарлиг юм. Эдүгээ олдоод байгаа 40 зүйл зарлигийг дотор нь;

1. Хааны зарлиг ja_og-liq 聖旨(2-5, 8-10, 13-24, 28-40-р дурсгал)

2. Хатны ижи 'i-ji 懿旨 (25, 26-р дурсгал)

3. Ван ноёд, ихэс дээдсийн үг 'eu-ge 令旨 (1, 6, 7, 11, 12-р дурсгал)

4. Багшийн фажи hua_o-ji 法旨 (27-р дурсгал) хэмээн 4 хувааж болно.

Эл зарлигуудыг буулгасан эзнээр нь ялгавал:

Хубилай хааны 4 (1277~1289 оны 3, 1280~1292 оны 1) зарлиг,

⁴ 2004 оны 6-р сарын 17-ны өдөр МУИС-ийн МХСС-ийн Түрэг судлалын III ангийн оюутнуудын хээрийн дадлага удирдаж явахдаа бид (Түрэг судлалын тэнхимийн эрхлэгч, доктор Ц. Баттулга, доктор Ё. Жанчив, багш Р. Мөнхтулга, Н. Гэрэлмаа нар) Тайхар чулуунаа нэг мөр дөрвөлжин үсгийн дурсгал байгааг шинээр илрүүлсэн билээ. Ё. Жанчив, Л. Батбилиг, Тайхар чулууны дөрвөлжин бичиг, (“Acta Historica”, МУБИС, т. V, f. 1-26, УБ., 2005, (175 тал), 164-166) өгүүллээс лавлана уу.

⁵ Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын 5-р багийн нутаг “Хавцалын адаг” хэмээх хадан хясаанаа хар бэхээр бичсэн дөрвөлжин бичгийн дурсгалыг МУИС-ийн багш М. Баярсайханы удирдсан тус сургуулийн Эх бичиг судлалын III ангийн оюутнууд 2005 оны 6-р сард нээн илрүүлж гэрэл зураг болон хуулбар хийж авсан байна. Гэвч тэдний хуулбар шаардлага хангахгүй байсан тул бид (МУИС-ийн багш М. Баярсайхан, Ц. Баттулга, Ё. Жанчив) 2005 оны 8-р сарын 3-ны өдөр газар дээр нь очин судалж, дижитал аппарат болон видео камераар зургийг нь авсан юм.

Ё. Жанчив, “Хавцалын адаг”-ийн дөрвөлжин бичгийн дурсгал, (“Acta Mongolica”, vol. 5(246), МУИС, Centre for Mongol Studies, УБ., 2005, (257 тал), 145-146) өгүүллээс үзнэ үү.

Өлзийт хааны 4 (1294, 1298, 1301, 1306 оны) зарлиг,
 Хайсан хүлэг хааны 1 (1309 оны) зарлиг,
 Буянт хааны зарлиг хамгийн олон буюу 10 (1312 оны 2, 1313 оны 1, 1314 оны 4, он цаг нь тодорхойгүй 2, 1218 оны 1) зарлиг,
 Гэгээн хааны 1 (1323 оны 1) зарлиг,
 Есөнтөмөр хааны 3 (1324 оны 2, 1228 оны 1) зарлиг,
 Тогоонтөмөр хааны 8 (1335 оны 1, 1336 оны 1, 1342 оны 1, 1343 оны 1, 1345 оны 1, 1351 оны 1, 1362 оны 1, 1368 оны 1) зарлиг,
 Эзэн ба он цаг нь үл мэдэгдэх зарлигийн хэсэг 1,
 Дармабалын хатны 2 (1320 оны 1, 1321 оны 1) ижи,
 Хубилай хааны хүү, Хуан-зи Ань-си ван Мангалын үг 1 (1276 он),
 Ананд чин вангийн үг 2 (1282 оны 1, 1283 оны 1),
 Се'үсегийн үг 1 (1303 он),
 Дармабалын хүү, хан хөвгүүн Хайшаны үг 1 (1305 он)
 Хааны багш Гунгаалодойжалцанбалсанбуугийн 1 (1321 он) фажи зэрэг болно.


Эдгээр зарлигаас,

- а. Хад, чулуун дээр сийлсэн 27 (1, 2, 4-9, 11, 13-21, 24, 26, 27, 32-35, 37, 40-р зарлиг)
- б. Цаасан дээр үйлдсэн 13 (3, 10, 12, 22, 23, 25, 28-31, 36, 38, 39-р зарлиг) зарлиг байна:

Эл зарлигуудийн ихэнх нь буюу 1, 2, 4-9, 11, 13-21, 24, 26, 27, 32-35, 37-р зарлиг нь нангиад монгол хоёр хэлээр байна.


Эдгээр зарлиг бүгд тогтсон үг хэллэг, загвартай байдаг. Жишээ болгож нэг зарлигийг авч үзье:

Тогоонтөмөр хааны зарлиг (1343)



1. Moŋ-k'e_o dē,ŋ-ri-yin k'u-č'un-dur
2. (yē₁)-ke su ja_o-li-yin 'i-h'en-dur
3. q'n ja_or-liq ma_o-nu
4. č'e-ri-'u-dun no-ya_od-da_o č'e-rig ha_o-ra_o-na_o ba_o-la_o-qa-
5. dun da_o-ru-qa_os-da_o no-ya_od-da_o yor-č'i-qun ya_o-bu-qun 'ē₁-č'i-ne d'ul-qa_o-quē₁
6. ja_or-liq
7. Jiŋ-gis qa_o-nu "eo-k'eo-deē₁ q'-nu se-č'en q'-nu "eol-jee₁-t'u q'-nu
8. k'eu-lug q'-nu bu-ya_on-t'u q'-nu ge-g'en q'-nu qu-t'uq-t'u q'-nu
9. rin-č'ē₁n-dpa_ol q'-nu ba_o ja_or-liq-dur do-yid 'ē₁r-k'e-'ud sen-šhi-ŋud "-li-ba_o "l-ba_o qub-č'i-
10. ri "eu-lu "eu-jen dē,ŋ-ri-yi ja_ol-ba_o-ri-ju hi-ru-'er "eo-gun "-t'u-qa_oyi k'eg-deg-sed
11. "-ju-'uē₁ 'ē₁-du-'e ber beo-'e-su 'u-ri-da_o-nu ja_or-li-qun yo-su-'r "-li-ba_o "l-ba_o qu-č'i-

12. ri "eu-lu "eu-jen dē₁ri-yi ja₀l-ba₀-ri-ju hi-ru-'er "eo-gun "-t'u-qa₀-yi k'ēn 'ē₁-ne šī-
13. la₀-šī-ri-(yi)n bos-qa₀q-sa₀n Ta₀y jiw lim zhi, Jun "uen zhi, Di ja₀y zhi k'i-'ed seu-
mes-dur
14. "-qun Lim gia₀n jeu t'e-ri-'u-t'en do-yid-da₀ ba₀-ri-ju ya₀-bu-'yi
15. ja₀r-liq "eog-beē₁ 'ē₁-de-nu seu-mes-dur ge-yid-dur "-nu 'ē₁l-č'in bu ba₀-u-t'u-qa₀-yi
16. 'u-l' šī-'u-su bu ba₀-ri-t'u-qa₀yi qa₀-ja₀r 'u-sun ba₀q t'e-gir-med ya₀-u k'e-di "-nu
17. k'ed k'ed ber bol-ju bu-li-ju t'a₀-t'a₀-ju bu "b-t'u-qa₀yi "-na₀ (qa₀)-ri-(ya₀)-t'a₀n ya₀-
'u k'e-di "-
18. nu ha₀-ra₀n yo-su "eu-ge-'u k'u-č'u k'ur-ge-'e-su t'en-de bu-k'un ba₀-
19. la₀-qa₀-dun no-ya₀d do-yi-dun "eo-t'eo-gus-lu-' qa₀m-t'u qa₀-
20. qa₀l-ju Lim Ge₁n jeu-da₀ t'ha₀-ul-ju "eog-t'u-geē₁ 'ē₁-de ba₀-
21. sa₀ do-yid
22. ja₀r-liq-t'u k'ē-ju yo-su "eu-ge-'un "euē₁-les bu "euē₁-
23. led-t'u-geē₁ "euē₁-le-du-'e-su mud ba₀-sa₀ "eu-lu-'u
24. "-yu-qun.
25. ja₀r-liq ma₀-nu ji-jin qu-t'u-'r hon qo-nin jil ju-nu t'e-ri-'un za₀-ra₀-yin qur-ba₀n
26. šī-ne-de Ta₀y-du-da₀ bu-k'ue₁-dur bi-č'i-beē₁.



1. Мөнх тэнгэрийн хүчинд
2. Их суу залийн ивээлд

3. Хаан зарлиг маань
4. Цэргүүдийн ноёдод, цэрэг ардад, балга-
5. -дын даргаст, ноёдод зорчин явах элч нарт дуулгах
6. зарлиг
7. Чингис ханы, Өгөдэй хааны, Сэцэн хааны, Өлзийг хааны,
8. Хүлэг хааны, Буянт хааны, Гэгээн хааны, Хутагт хааны,
9. Ринченбал хааны ба хааны зарлигт тойд, эрхүүд, сэншинүүд аливаа алба гувчуур
10. үл үзэн тэнгэрийг залбирч, ерөөл өгөн атугай хэмээгдэгсэд
11. ажгуу. Эдүгээ бээр бөгөөс урьдны зарлигийн ёсоор аливаа алба гувчуур
12. үл үзэн тэнгэрийг залбирч, ерөөл өгөн атугай хэмээн энэ Ши-
13. лаширийн босгосон Да жу линь си, Жун юнь си, Ди жай си хийгээд сүмст
14. ахун Линь жян жу тэргүүтэн тойдод барьж явах
15. зарлиг өгвэй. Эдний сүмст, хийдэд нь элчин бүү буутугай.
16. Улаа шүүс бүү барьтугай. Газар, ус, цэцэрлэг, тээрэм, юу хээг нь
17. хэд хэд бээр болж булааж татаж бүү автугай. Тэдэнд харьяатан юу хээг нь
18. ард ёс үгүй хүч хүргэвээс тэнд бүхүн бал-
19. гадын ноёд, тойдын өтгөс лүгээ хамт ха-
20. галж Линь жян жу-д даалгаж өгтүгэй. Эд бас
21. тойд
22. зарлигт хэмээж ёс үгүй үйлс бүү үйлд-
23. түгэй. Үйлдвээс мөн бас үл
24. айх уу?
25. Зарлиг маань жи жин гутгаар он, хонин жил, зуны тэргүүн сарын гурван
26. шинэдээ Дайду-д бүхүйд бичвэй⁶.

Уул зарлигийн бүтцийг авч үзвэл:

1. Эхлэл буюу титим үг (Мотивировочные статьи⁷, Formules initiales⁸): 1-3-р мөр,
2. Захидлыг хүлээн авагч (Статьи, содержащие обращение⁹): 4-6-р мөр,
3. Өмнөх хаадын нэр ус, буулгасан зарлигийн агуулга: 7-11-р мөр,
4. Уг зарлигийн гол агуулга: 11-15-р мөр,
5. Уг зарлиг хүлээн авагчаас гадна бусад хүнд хандсан үг: 15-20-р мөр,
6. Уг зарлигийг хүлээн авагчид хандсан үг: 20-24-р мөр,
7. Зарлигийг үйлдсэн огноо болоод газар орон (Удостоверительные статьи¹⁰): 25-26-р мөр гэсэн нарийн чанд бүтэцтэй бөгөөд энэ нь бусад бүх зарлиг тушаалд давтагддаг билээ.

Зарлиг тушаал буулгагч өөрийнхөө нэрийг оруулдаггүй, харин Чингис ханаас эхлээд өөрийнхөө үе хүртэлх хаадын нэрийг дурддаг байна. Жишээлбэл, эл зарлигт

⁶ Эл зарлигийн үг хэлтэгийн тайлбарыг Ё. Жанчив, Монгол дөрвөлжин үсгээр бүхий Тогоонтөмөр хааны хонин жилийн зарлиг, ("Монгол судлалын ЭШБ", МУИС, МСС, УБ., 2000. (284 тал), 77-86) өгүүллээс үзнэ үү.

⁷ А.П.Григорьев, Монгольская дипломатика XIII-XV вв. Л., 1978 (136 cc), 17-33

⁸ W. Kotwicz, Formules initiales des documents mongoles aux XIIIe et XIVe siècles, RO, t. X, 1934, 131-157

⁹ А.П.Григорьев, Монгольская дипломатика XIII-XV вв. Л., 1978 (136 cc), 33-55

¹⁰ А.П.Григорьев, Монгольская дипломатика XIII-XV вв. Л., 1978 (136 cc), 55-70

Тогоонтөмөр хаан, “*Чингис ханы, Өгөдэй хааны, Сэцэн хааны, Өлзийг хааны, Хүлэг хааны, Буянт хааны, Гэгээн хааны, Хутагт хааны, Ринченбал хааны*” хэмээн өмнөх хаадынхаа нэрийг дурдаж байна.

Дөрвөлжин үсгийн зарлигуудад дээрх загвар бүтцийн 1, 3, 5-р зүйл нэгэн адил давтагдаж, харин үлдсэн зүйлүүдийн нэр ус солигдож байдаг байна.

Хаад ихсийн зарлигийн агуулгыг авч үзвэл:

А. Аливаа сүм хийд, албан тушаалтныг аливаа алба гувчуураас чөлөөлсөн зарлиг ихэнх хувийг эзэлж байна. Үүнийг Оросын эрдэмтэн А.П.Григорьев “Тарханные грамоты храмам и монастырям”¹¹ хэмээн нэрлэжээ. Бидний дээр авч үзсэн зарлиг энэ төрөлд хамаарах юм.

Б. Албан тушаалд томилсон зарлиг

Есөнтөмөр хааны зарлиг (1328)

Тогоонтөмөр хааны зарлиг (1362)

Энэ хоёр зарлигийн холбогдох хэсгийг сийрүүлвэл:

Есөнтөмөр хааны зарлиг (1328):

- ...
1. ga₀m geun min wa₀n γu huu-dur **wa₀n** γu bol-ju t'a₀-ni me-
 2. de-ju "-li-ba₀ "l-ba₀ qub-č'i-ri ja₀m č'e-ri-gun c'a₀η t'a₀m-qa₀-
 3. yin "euē₁-le-ši k'u-yi-č'i-'e-'u-lun "-t'u-qa₀yi k'ēn 'od-
 4. zē₁r-rgel <rgia₀l>-mc'a₀-na₀ yē₁-ke k'e-r'e
ja₀r-liq t'a₀m-qa₀ "eog-beē₁

1. Гань гунь минь вань ху фу-д **вань ху** болж танийг мэ-
2. дэж а алба гувчуур, зам, цэргийн сан там-
3. гын үйлсийг гүйцээн атугай хэмээн Од-
4. сэржалцанаа их хэрээ (гэрэгэ) зарлиг тамга өгвэй.

Тогоонтөмөр хааны зарлиг (1362):

19. 'ē₁-ne yon-da₀n-rgia₀l-mc'a₀-ni c'a₀-'oηs
20. ge-bun 'o-ro-na₀ bon 'bo-run qa₀-ja₀-ra₀ jē₁w
21. t'aw-shi-yin **jē₁w** t'a₀w-šhi bol-qa₀n t'eu-ši-
22. ju 'i-le-beē₁. "-li-ba₀ "l-ba₀ qub-č'i-
23. ri ja₀m č'e-ri-gun c'a₀η t'a₀m-qa₀-yin "-qa₀r-
24. t'a₀-ma₀r k'i-'ed "euē₁-le-si k'u-yi-č'i-
25. 'e-'u-lun "-t'u-qa₀yi k'ēn
26. ja₀r-liq "eog-beē₁

¹¹ А.П.Григорьев, Монгольская дипломатика XIII-XV вв. Л., 1978 (136 сс), 71-106

19. энэ Ёндонжалцаныг Ца-он-
20. гэбийн орноо бонборын газраа жао
21. тао ши-гийн **жао тао ши** болгон тү-
22. шиж илгээвэй. Аливаа алба гувчуур,
23. зам, цэргийн сан тамгын ахар
24. тамар хийгээд үйлсийг гүйцүү-
25. лэн атугай хэмээн
26. зарлиг өгвэй

Энэхүү 1328 оны Есөнтөмөр хааны зарлигт Одсэржалцан хэмээх хүнийг Төвдийн Исмааргам хэмээх газрын “Цэрэг ардын түмний ордон” (“军民万户”)-ы “**waon yu**” буюу “түмний ноён” (“万户”)-оор томилж, “их гэрэгэ зарлиг тамга” өгсөн тухай өгүүлж байна.

Дараачийн буюу 1362 оны Тогоонтөмөр хааны зарлигт Ёндонжалцан хэмээх хүнийг мөн л Төвд газарт **жао тао ши** (“招讨使”) хэмээх албан тушаалд томилсон талаар гарч байна.

Ийнхүү дөрвөлжин үсгээр бүхий хаад ихсийн зарлиг нь дундад үеийн монгол хэлний үнэ цэнэтэй баримт болохоос гадна Их Монгол улсын түүх соёл, нийгмийн байгуулал, эдийн засаг зэрэг олон асуудлыг судлахад чухал сурвалж болж өгөх юм.

В. Гэрэгэний бичээс

Хятадууд маш эрт үеэс пайз (The tablet of authority or the token) хэрэглэсээр иржээ. Тан, Сун, Ляо, Алтан улсын үед цөм пайз хэрэглэж байсан археологийн болон түүх сурвалжийн баримт байдаг билээ. Монголчууд Хятадын нөлөөгөөр эрт цагаас пайз хэрэглэх болжээ. Монгол хаад төрийн аливаа чухал хэрэгт сайд, элчин, түшмэл, жанжин зэрэг өөрийн төлөөний хүмүүсийг томилохдоо тэдгээрийн зэрэг дэв, эрх хэмжээ, албан тушаалыг илэрхийлсэн пайз олгодог байжээ¹².

¹² Пайзын судлалаар гарсан ном бүтээл гэвэл:

Д.Банзаров. Пайзе, или металлические дощечки с повелениями монгольских ханов, С предисловием и примечаниями П.Савельева. ЗСПАНО. Том.2, вып.1, Спб.,1850. (79-97), 79-81; Сборник “Чёрная вера...”, Под.ред.Г.Н.Потанина, Спб.,1891, (47-64), 52; Д.Банзаров, Собрание сочинений. М.,1955, 140-160, reprint. 1997. 80-90

Д.Банзаров. Разъяснение одной монгольской надписи на серебряной дощечке, найденной барона А.фон Штиглиц, Д.Банзаров. Собрание сочинений. М.,1955. 125-139, reprint. 1997. 71-79

Ц. Ж. Жамцарано. Пайзы у монголов в настоящее время, ЗВОРАО. 1914, т. XXII. 55-159

Ё. Жанчив, Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалууд, Corpus Scriptorum, т. II, УБ., 2005. (240 тал), 79-80

О. Латтимор, Монгол гүрний үеийн эрх мэдлийн пайзны асуудал буюу байдал. ОУМЭ-ий II их хурал, I боть, УБ., 1973, 241-242

Х. Пэрлээ, Монголын түүх судлах сурвалжийн нэгэн нь пайз мөн. “Түүхийн судлал”, т. XII, УБ., 1976. 90-99

D.Banzarow. Erklärung einer mongolischen Inschrift auf einer im Jekaterinoslawischen Gouvernement auf den Gütern des Herrn Barons A. von Stieglitz ausgegrabenen Silberplatte. Bulletin. Y, 9, 1848. Spb.,129-139+1tab.

D.Banzarow. Paise oder Metallplatten mit den Befehlen der mongolischen chane, als Inschrift. “Mém. de la Soc. Imp. d’Archéol. St.petersb.”.Paris-Berlin, 1859. vol. 5, (328-339). 333-334, vol. 6, 441-448

F. W. Cleaves. Daruya and Gerege, HJAS, vol. 16, № 1-2, 1953. 237-259

Пайзыг алт, мөнгө, төмөр, гууль зэрэг метал болон модоор ч хийдэг байсан аж. Алтан пайзийг онц тусгай эрхтэй элчид олгодог байсан бол доорд зиндааныханд модон пайз олгож байсан бололтой.

Эдүгээ уламжлан ирсэн пайзийг үзвэл, хэлбэр дүрсийн хувьд урт гонзгой (long-squared), дугариг (round shaped) гэсэн хоёр зүйл байна.

Эдгээр пайз нь дотроо барсын толгойт алтан пайз, барс хэрэлдэгч алтан пайз, арслан толгойт пайз, шонхорт пайз гэх зэрэг хэд хэдэн янз байжээ.

Пайзын дээрх үсэг ч нангиад, уйгуржин, хятан, дөрвөлжин, араб зэрэг хэдэн зүйл буй.

Пайз нь зориулалтын хувьд элчний болон байцаах пайз гэсэн хоёр янз байдаг.

Пайзны талаар Хятадын жуулчин Жао Хуны “Монгол татарын бүрэн тэмдэглэл”, Пэн Да-я, Сү Тин нарын “Хар татарын хэргийн товч”, “Юань улсын судар”, Персийн түүхч Ата-Малик Жүвейнийн “Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх”, Францын жуулчин Виллям Рубруккийн “Монголчуудын түүх”, Италийн жуулчин Марко Пологийн “Марко Пологийн ном” зэрэг сурвалжуудад тэмдэглэсэн байдаг билээ¹³.

Орчин цагийн монгол хэлнээ хэрэглэгдэж буй “пайз” хэмээх үг нь нангиад хэлний “牌子 pái•zi” буюу “тэмдэг” гэсэн үг ажгуу. Энэ үгийг уйгуржин монгол үсгийн дурсгалуудад “gerege, gerige”¹⁴ хэмээн тохиолддог бол эл үг дөрвөлжин үсгийн монгол дурсгалд хоёрхон удаа гарч байгааг доор сийрүүлвэл:

1328 оны Есөнтөмөр хааны зарлигт:

3. 'od-
4. zé₁r-rgel <rgia₀l>-mc'a₀-na₀ yé₁-ke k'e-r'e ja₀r-liq t'a₀m-qa₀ "eog-bee₁
3. Од-
4. сэржалцанаа их хэрээ (гэрэгэ) зарлиг тамга өгвэй.

Хятадын нутгаас хожуувтар олдсон пайзын бичээст:

1. mu-qu-gi-qu k'e-r'e
1. мухрих (цаазлах) хэрээ зэрэг болно.

Энэхүү гэрэгэ, хэрээ хэмээх үгийн гарлыг судлаачид гэрч, гэрчлэх зэрэг үгтэй холбон тайлбарладаг. Тухайлбал проф. Ф. В. Кливез daru-ya хэмээх үгийн нэгэн адил gere- хэмээх үйл язгуурт үйлээс нэр үг бүтээх -ge дагавар залгаж бүтсэн байж болох юм хэмээн үзжээ¹⁵.

L. Ligeti, Deux tablettes de T'ai-tsong des Ts'ing, AOH, t. VIII, f. 3, Budapest, 1958, 201-239

N.Ts. Munkuyev, A New Mongolian P'ai-tzu from Simferopol, AOH, t. XXXI, f. 2, 1977, 185-215

I. de Rachewiltz, Papal Envoys to the Great Khans, Faber and Faber, London, 1971

Yang Hye-suk, The Foreign Policy of the Great Mongol Empire and the Paiza, "The Image of Mongolia in European and Asian Travel Literature", Ulaanbaatar, 2006, (142 pp), 101-108

Ханз үсгээр гарсан бүтээлийн номзүйг Yang Hye-suk-ийн дээрх өгүүллийн 101-р тал дахь 2-р зүүлтээс үзнэ үү.

¹³ Yang Hye-suk, The Foreign Policy of the Great Mongol Empire and the Paiza, "The Image of Mongolia in European and Asian Travel Literature", Ulaanbaatar, 2006, (142 pp), (101-108), 103-106

¹⁴ F. W. Cleaves, Daruya and Gerege, HJAS, vol. 16, № 1-2, 1953, 237-259


¹⁵ F. W. Cleaves, Daruya and Gerege, HJAS, vol. 16, № 1-2, 1953, 237-259

Одоо дөрвөлжин үсгийн пайзыг авч үзье¹⁶.

А. Зарлигийн пайз

1. Минусийн пайз (Алтан үсэгт гонзгой мөнгөн пайз)

Уул пайзыг 1846 онд Енисей мужийн Минусинск хэмээх газраас олжээ. Бичээсийг нь сийрүүлвэл:




- А 1. moŋ- k'e_o
2. dē_iŋ-ri-yin k'u-č-un-dur
3. q'n ne-re qu-t'uq-t'a_oyi
В 4. bol-t'u-qa_oyi k'en "eu-lu bu-
5. šī-re-gu "l-da_o-qu "eu-k'u-gu

1. Мөнх
2. тэнгэрийн хүчинд
3. хаан нэр хутагтай
4. болтугай. Хэн үл биш-
5. рэх аллах үхэх.

2. Ньюкийн пайз (Алтан үсэгт гонзгой мөнгөн пайз)

Уг пайзыг 1853 онд Орос улсын Байгал нуур хавийн Ньюк хэмээх газраас олсон байна. Бичээсийг нь сийрүүлвэл:




- А 1. moŋ-qa_o
2. dē_iŋ-ri-yin k'u-č-un-dur
3. q'n ne-re qu-t'uq-t'a_oyi
В 4. bol-t'u-qa_oyi k'en "eu-lu bu-
5. šī-re-gu "l-da_o-qu "eu-k'u-gu

1. Мөнх
2. тэнгэрийн хүчинд
3. хаан нэр хутагтай
4. болтугай. Хэн үл биш-
5. рэх алдах үхэх.

¹⁶ Дөрвөлжин үсгийн пайзын судалгааны бүтээлүүдийн номзүйг Ё. Жанчив. Дөрвөлжин үсгийн монгол дурсгал (Эх. үсгийн галиг, хөрвүүлэг, үгийн хэлхээ, номзүй), MONUMENTA MONGOLICA: т. III. Centre for Mongol Studies, National University of Mongolia. УБ., 2002. (195 тал), номын 129-132-р тал дахь номзүйгээс үзнэ үү.

3. Боготолын пайз (Мөнгөн үсэгт дугариг төмөр пайз)

Орос улсын Томск хотын ойролцоох Боготол хэмээх газраас олдсон бөгөөд 1881 онд анх сонинд нийтлэгджээ. Бичээсийг нь сийрүүлвэл:



1. moŋ-k'e₀ dē₁ŋ-ri-
2. yin k'u-ē-un-dur
3. q'-nu ja₀r-liq k'en
4. 'ē₁-se bu-ši-r'e-su
5. 'l-da₀-t'u-qa₀yi.

1. Мөнх тэнгэ-
2. рийн хүчинд
3. хааны зарлиг хэн
4. эс биширвээс
5. алдтугай.

Үүнтэй яг адил пайзыг Ганьсу мужийн музей 1965 онд олж авсан ажээ.

4. Дашлхүмбийн пайз (Алтан үсэгт дугариг төмөр пайз)

Төвдийн Дашлхүмбэ хийдэд хадгалагдаж байна. 1995 онд зургийг нь анх нийтэлжээ. Хэлбэр хэмжээ, үсгийн хувьд Боготолын пайзтай адилхан. Бичээсийг нь сийрүүлвэл:




1. moŋ-k'e₀ dē₁ŋ-ri-
2. yin k'u-ē-un-dur
3. q'-nu ja₀r-liq k'en
4. 'ē₁-se bu-ši-r'e-su
5. 'l-da₀-t'u-qa₀yi

1. Мөнх тэнгэ-
2. рийн хүчинд
3. хааны зарлиг хэн
4. эс биширвээс
5. алдтугай.

*В. Байцаах пайз


5. Б. И. Панкратовын пайз (Дугариг гуулин пайз)

Оросын эрдэмтэн Б. И. Панкратов 1925 онд Бээжингээс олж авчээ. Өвөр талдаа дөрвөлжин, уйгуржин монгол, перс, ар талдаа нангиад үг үсэгтэй. Бичээсийг сийрүүлвэл:



1. ja_or t'uη-qa_oq ma_o-u-
2. ni se-reg-de-k'u.

Зар тунхаг муу-
ныг сэрэгдэх.





6. Хятадаас хожуувтар олдсон пайз (Дугариг гуулин пайз)

Хятадын Янжугаас олдсон өвөр талдаа дөрвөлжин, перс, ар талдаа нангиад 3 зүйл үсгийн бичээстэй пайз буй. Бичээсийг сийрүүлвэл;



1. mu-qu-di(<ri)-qu k'e-r'e.
1. Мухрих (цаазлах) хэрээ.


Мөн Хятадаас олдсон үүнтэй ижил төстэй, өвөр талдаа уйгуржин монгол, дөрвөлжин, перс, төвд, ар талдаа нангиад 5 зүйл үсгийн бичээстэй дугариг гуулин пайз буй. Бичээсийг сийрүүлвэл:



1. mu-qu-ri-qu k'e-r'e.
1. Мухрих (цаазлах) хэрээ.

7. Өвөр Монголын Хянгaн аймгаас олдсон Солон алтан пайз
(Гонзгой алтан пайз)

Энэхүү алтан пайзыг 2000 оны орчим ӨМИС-ийн Монгол судлалын хүрээлэнгийн эрдэмтэд Хянгaн аймгийн Хорчин баруун гарын өмнөд хошууны Солон балгасны хоёр залуугаас худалдан авчээ¹⁷. Эл алтан пайзын бичээс өмнөх Минус, Ньюкийн пайзын бичээстэй бүрэн адил байна. Бичээсийг сийрүүлвэл:



- A 1. moŋ- k'e_o
2. dē,ŋ-ri-yin k'u-č-un-dur
3. q'n ne-re qu-t'uq-t'a_oyi
B 4. bol-t'u-qa_oyi k'en "eu-lu bu-
5. ši-re-gu "l-da_o-qu "eu-k'u-gu

1. Мөнх
2. тэнгэрийн хүчинд
3. хаан нэр хутагтай
4. болтугай. Хэн үл биш-
5. рэх алдах үхэх.

Одоогоор олдож судлагдаад байгаа дөрвөлжин үсгийн пайз гэвэл эдгээр болно. Цаашид шинэ шинэ дурсгал олдох нь эргэлзээгүй буй за.

С. Тамга захирлагийн бичээс

Монголчууд төрт ёсны баялаг уламжлалтай ард түмэн бөгөөд Хүннүгийн үеэс эхлэн төрийн тамга хэрэглэж иржээ¹⁸. “Төрийн тамга бол тухайн улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын илэрхийлэл, хууль цаазны батламж, төр ёсны бэлгэ тэмдэг болсоор ирэв”¹⁹.

¹⁷ Bousiang. Orčimqan Öbür Mongyol-du olju ileregülügen Yuvan-u üy-e-yin mongyol dörbeljin üsügtü qaγan-u altan payisa. “Oyun-u čečeges-ün baylay-a. Flowers of Wisdom”. Möngkejayay-a nayirayulba. ÖMYSKQ. 2002. (439 pp), 325-336

¹⁸ Тамгын талаар гарсан гол гол бүтээл гэвэл;

Х. Нямбуу. Д. Өлзийдолгор, Ё. Жанчив, Д. Дашдулам, Монгол төрийн тамга. “МУИС, НУФ, ЭШБ”, № 3 (127). УБ., 1997, 9-25

Х. Нямбуу, Д. Өлзийдолгор, Ё. Жанчив, Д. Дашдулам, Монгол төрийн тамга. “Mongolica: An International Annual of Mongol Studies”, vol.10(31), УБ., 2000 (A Special Issue Containing the Papers of the Seventh International Congress of Mongolists Convened by under the Patronage of N. Bagabandi, Presedent of Mongolia, 12-16 Aug. 1997. UB), 195-208

Д. Өлзийдолгор, Монгол улсын төрийн тамга, УБ., 1999, 250 тал

Х. Пэрлээ, Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь, УБ., 1976

Х. Пэрлээ, Монголын тамга зүйн асуудалд, “Түүхийн судлал”, т. XV, УБ., 1983, 40-53

Čolmon, Mongyol tamay-a seyilümel, ÖMSKKQ. 1996


D. M. Farquhar, The Official Seals and Ciphers of the Yuan Period. “MoSe”. vol. XXV, 1966, 362-393

照那斯图, 元巴思八字篆体书官印辑存, “文物资料丛刊”1. 文物出版社. 北京. 1977, 68-83

¹⁹ Д. Өлзийдолгор, Монгол улсын төрийн тамга, УБ., 1999, (250 тал). 6

Тамгын бичээсийг ихэвчлэн эвхмэл үсгээр үйлддэг билээ.

Дөрвөлжин үсгээр үйлдсэн, монгол үг үсэг орсон тамга болон тамгын дардас бидний олж мэдсэнээр эдүгээ 7 байгаа юм²⁰. Эдгээрээс хамгийн эртнийх нь 1305 оны Өлзийт султаны тамгын дардас болно²¹. Жишээ болгон “Номч мэргэн хамбо”-ийн тамгын бичээсийг авч үзье:





1. nom-č'i
2. mer-gen
3. mk'aon-po

1. Номч
2. мэргэн
3. хамбо

Юань гүрний үед дөрвөлжин үсгийн эвхмэл тигээр, нангиад хэлээр үйлдсэн зуу гаруй тамга болон тамгын дардас олдоод байгаагийн хамгийн эртнийх нь 1274, хожуухан үеийнх нь 1382 оны тамгын бичээс буй²².

Эдгээрээс жишээ болгон Монгол-Германы хамтарсан шинжилгээний ангийхан Монголын эртний нийслэл Хархорум хотын тууринаас 2001 онд малтан гаргасан 1372 оны тамгын бичээсийг авч үзье:



Тамгын бичээсийг галиглавал;

1. yu-pu
2. jeu-čhi
3. ji-yin
хэмээх үг ажгуу²³.

Нангиадаар сэргээн галиглавал;

户部 hù-bù “Сангийн явдлын
主事 zhǔ-shì яамны эрхилсэн
之印 zhī-yin түшмэлийн тамга”

²⁰ Дөрвөлжин үсгийн монгол тамгын талаар Ё. Жанчив, Дөрвөлжин үсгийн монгол дурсгал (Эх, үсгийн галиг, хөрвүүлэг, үгийн хэлхээ, номзүй), MONUMENTA MONGOLICA: t. III, Centre for Mongol Studies, National University of Mongolia, УБ., 2002, (195 тал), номын 133-135-р талаас үзнэ үү.

²¹ G. Doerfer, Mongolica aus Ardabil, ZAS, Wiesbaden, 1975, (ss. 187-263), 208, 249

²² Юань гүрний үеийн эдгээр тамгын бичээсийн талаар дараахь бүтээлүүдээс лавлана уу.

Ё. Жанчив, Дөрвөлжин үсгийн монгол дурсгал (Эх, үсгийн галиг, хөрвүүлэг, үгийн хэлхээ, номзүй), MONUMENTA MONGOLICA: t. III, Centre for Mongol Studies, National University of Mongolia, УБ., 2002, (195 тал), 14

Д. Өлзийдолгор, Монгол улсын төрийн тамга, УБ., 1999, 250 тал

D. M. Farquhar, The Official Seals and Ciphers of the Yuan Period, “MoSe”, vol. XXV, 1966, 362-393

照那斯图, 元巴思八字篆体书官印辑存, “文物资料丛刊”1, 文物出版社, 北京, 1977, 68-83

Төгсгөлд нь тэмдэглэхэд, дөрвөлжин үсгийн албан бичгийн дурсгалуудыг тухайн үеийнх нь уйгуржин монгол, нангиад, араб, перс зэрэг олон хэл бичгээр тэмдэглэсэн бусад дурсгалуудтай харьцуулан үзэж, тал бүрээс нь нягтлан судлах шаардлагатай байна.

Лавлаж ашигласан ном зохиол


1. А.П.Григорьев, Монгольская дипломатика XIII-XV вв. Л., 1978, 136 сс
2. Ё. Жанчив, Монгол дөрвөлжин үсгээр бүхий Тогоонтөмөр хааны хонин жилийн зарлиг, “Монгол судлалын ЭШБ”, МУИС, МСС, УБ., 2000, (284 тал), 77-86
3. Ё. Жанчив, Дөрвөлжин үсгийн монгол дурсгалын хэлний судалгаа, (Хэл бичгийн ухааны доктор (Ph. D)-ын зэрэг горилсон зохиол), УБ., 2000, 188+162 тал
4. Ё. Жанчив, Дөрвөлжин үсгийн монгол дурсгал (Эх, үсгийн галиг, хөрвүүлэг, үгийн хэлхээ, номзүй), MONUMENTA MONGOLICA: t. III, Centre for Mongol Studies, National University of Mongolia, УБ., 2002, 195 тал
5. Ё. Жанчив, “Хавцалын адаг”-ийн дөрвөлжин бичгийн дурсгал, “Acta Mongolica”, vol. 5(246), МУИС, Centre for Mongol Studies, УБ., 2005, (257 тал), 145-146
6. Ё. Жанчив, Л. Батбилиг, Тайхар чулууны дөрвөлжин бичиг, “Acta Historica”, МУБИС, t. V, f. 1-26, УБ., 2005, (175 тал), 164-166
7. Х. Нямбуу, Д. Өлзийдолгор, Ё. Жанчив, Д. Дашдулам, Монгол төрийн тамга, “МУИС, НУФ, ЭШБ”, № 3 (127), УБ., 1997, 9-25
8. Х. Нямбуу, Д. Өлзийдолгор, Ё. Жанчив, Д. Дашдулам, Монгол төрийн тамга, “Mongolica. An International Annual of Mongol Studies”, vol.10(31), УБ., 2000 (A Special Issue Containing the Papers of the Seventh International Congress of Mongolists Convened by under the Patronage of N. Bagabandi, Presedent of Mongolia, 12-16 Aug. 1997, UB), 195-208
9. Д. Өлзийдолгор, Монгол улсын төрийн тамга, УБ., 1999, 250 тал
10. Н. Н. Поппе, Квадратная письменность, М.-Л., 1941, 168 сс
11. Х. Пэрлээ, Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь, УБ., 1976
12. Х. Пэрлээ, Монголын түүх судлах сурвалжийн нэгэн нь пайз мөн, “Түүхийн судлал”, т. XII, УБ., 1976, 90-99
13. Х. Пэрлээ, Монголын тамга зүйн асуудалд, “Түүхийн судлал”, т. XV, УБ., 1983, 40-53
14. Б. Сумьяабаатар, Хархорины тамгын бичээсийг тайлан уншсан нь, “ШУА-ийн мэдээ”, УБ., 2002, № 1/ 163, (105 тал), 58-69
15. Төмөртоогоо, Монгол дөрвөлжин үсэгийн дурасгалын судалгаа (Удирдхал, эх бичиг, үсгийн хэлхээ, ном зүй), Monuments in Mongolian Language, The International Association for Mongol Studies, vol. II, УБ., 2002, 182 тал
16. Д.Чойжалсүрэн, Монголын дөрвөлжин үсэг, УБ., 1974, 12 тал
17. Bousiang, Orčimqan Öbür Mongγol-du olju ileregülügsen Yuvan-u üy-e-yin mongγol dörbeljin üsügtü qayan-u altan payisa, “Oyun-u čečeges-ün baylay-a, Flowers of Wisdom”, Möngkejayay-a nayirayulba, ÖMYSKQ, 2002, (439 pp), 325-336
18. M. Lewicki, Les inscription mongoles inédites en écriture carrée (=CO. No. 12), Wilno, 1937, 72 pp

²³ Б. Сумьяабаатар. Хархорийны тамгын бичээсийг тайлан уншсан нь, “ШУА-ийн мэдээ”, УБ., 2002, № 1/ 163. (105 тал), 58-69



19. F. W. Cleaves, Daruḡa and Gerege, HJAS, vol. 16, № 1-2, 1953, 237-259
20. W. Kotwicz, Formules initiales des documents mongoles aux XIIIe et XVe siècles, RO, t. X, 1934, 131-157
21. L. Ligeti, 'Phags-pa írásos emlékek. Kancellárai iratok kinai atírásban: Mongol Nyelvemlékektár II, Budapest, 1964, (155 pp), 3-116
22. L. Ligeti, Monuments en écriture 'Phags-pa. Pièces de chancellerie en transcription chinoise, MLMC. III, Budapest, 1972, (170 pp), 9-128
23. N. Ts. Munkuyev, A New Mongolian P'ai-tzu from Simferopol, AOH, t. XXXI, f. 2, 1977, 185-215
24. N. Poppe, The Mongolian Monuments in hP'ags-pa Script, (=Göttinger Asiatische Forschungen 8), Trans. and ed. by J. R. Krueger, Wiesbaden, 1957, XII+147 pp+13 pl+1 map
25. Yang Hye-suk, The Foreign Policy of the Great Mongol Empire and the Paiza, "The Image of Mongolia in European and Asian Travel Literature", Ulaanbaatar, 2006, (142 pp), 101-108
26. 照那斯图, 元巴思八字篆体书官印辑存, "文物资料丛刊"1, 文物出版社, 北京, 1977, 68-83
27. 照那斯图, 巴思八字和蒙古语文献, I. 研究文集, 東京, 1990, 169 pp, II. 文献汇集, 東京, 1991, 228 pp
28. 呼格吉勒图, 萨如拉, 巴思八字蒙古语文献汇编, 内蒙古教育出版社, 2004, 537 pp

Abstract

In this article author prepared a full list of mongolian monuments in 'phags-pa script and studied inscriptions of edicts of emperors and dignitaries, tablets of authority and seals related to official documents of XIII-XIV centuries. Especially, included a brief descriptions, photocopies of original monuments, transliterations and cyrillic renditions of all mongolian tablets of authority.



Есөнтөмөр хааны зарлиг (1328?)



Тамгын бичээсийг галиглавал; moŋ-qol geun-ba, yu-yin, нангиадаар сэргээн галиглавал: 蒙古軍百戶印 měng-gǔ jūn-bǎi hù-yìn, монголчилвол: “Монгол цэргийн зуутын ноёны тамга”